

Metals Mongolia - 2013

Т.Мөнхбат – Оюу Толгой ХХК, Дэд захирал

“Хүчирхэг аж үйлдвэрийг хөгжүүлэх нь”

Хүндэт Засгийн газрын гишүүд, хөрөнгө оруулагчид, зочид төлөөлөгчид, ноёд хатагтай нар аа,

Би Уул уурхай, металлургийн салбарт хөрөнгө оруулагчдын хоёрдугаар чуулганд Засгийн газар болон гуравдагч хөршийн хөрөнгө оруулагчдын хамтран хэрэгжүүлж буй Оюу Толгой төслийг төлөөлөн үг хэлж буйдаа баяртай байна.

Энэ жилийн үүлзалт хоёрдахь удаагаа зохиогдож буй “залуу” чуулган хэдий ч тус чуулганы анхдугаар хурал тун амжилттай явагдсаныг тод санаж байна.

Олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, тэдний сонирхлыг хөтлөх замаар эдийн засгийн өсөлт хөгжлийг бий болгоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг энэ төрлийн хурал чуулганы үйл ажиллагаанд Оюу Толгой компанийн зүгээс идэвхтэй оролцож ирсэн. Энэ удаагийн чуулганд **бид** мөн “Алтан” ивээн тэтгэгчээр оролцож байгаадаа туйлын баяртай байна.

[Төслийн сүүлийн үеийн мэдээ]

Та бүхний олонхи нь Өмнийн говьд эхлүүлсэн Оюу Толгой төсөл өдгөө барилга, бүтээн байгуулалтын ажлынхаа Эхний Үе шатны ард гарч, үйлдвэрлэлээ явуулах, бүтээгдэхүүнээ борлуулах үйл ажиллагаанд шилжээд байгааг сайн мэдэж байгаа гэж бодож байна.

Юуны өмнө Та бүхэнд Оюу Толгой төслийн хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг хүргэх нь зүйтэй болов уу.

2012 оны эцсээр бид баяжуулах үйлдвэрээ туршилтаар эхлүүлэн 2013 оны 6-р сар хүртэл үйлдвэрлэлээ тасралтгүй нэмэгдүүлж 7-р сарын эхээр анхны баяжмалаа экспортод гаргасан.

Оюу Толгойн зэсийн баяжмалыг дэлхийн зах зээлийн үнээр худалдан авч буй манай хэрэглэгчид сар гаруйн өмнө БНХАУ-ын хил, гааль дээр үүсээд байсан тээврийн асуудлуудаа цэгцэлж дууссанаар манай бүтээгдэхүүнийг хүлээн авах бололцоо бүрдээд байна.

Энэ оны 9-р сарын эцсийн байдлаар Оюу Толгойд нийтдээ 12.5 сая тонн хүдэр боловсруулах ажил хийгдээд байна. Энэ хугацаанд бид 160 мянган тонн баяжмал буюу 43 мянган тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлээд байна.

2013 оны эцэс гэхэд 85 мянган тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлэхээр ажиллаж байна.

Оюу Толгой компанийн хувь нийлүүлэгчид болох Эрдэнэс Оюу Толгой компани, Туркойз Хилл болон Рио Тинто компаниудын хувьд далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн явуулахын тулд зарим асуудлыг нааштайгаар шийдвэрлэх яриа хэлэлцээрүүд үргэлжилсэн хэвээр байна.

Эдгээр өдрүүдэд Оюу Толгой компанийн зүгээс Өмнөговь аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх, тэр дундаа Ханбогд сумтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээнд заасан амлалт үүргийнхээ хүрээнд нэлээдгүй ажлуудыг өрнүүлж байна.

Энэ онд бид олон улсын стандартад нийцсэн Ханбумбат нисэх буудлыг ашиглалтад оруулсан бол уурхайгаас хилийн боомт хүртэл барих хатуу хучилттай замын ажил 80% -тай явж байна.

Мөн Ханбогд суманд 5 км замыг хатуу хучилттай болгох ажил үндсэндээ дуусч байна. Харин ирэх долоо хоногт Ханбогд сумыг байнгын эрчим хүчээр хангах цахилгааны дэд станцын барилга, байгууламжийг **улсын комисс** хүлээн авах ажил явагдана.

Ингэснээр Ханбогд сумыг Оюу Толгойн уурхайгаас эрчим хүчээр хангаж, энэ ажлыг цаашид Өмнийн Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ компани үргэлжлүүлэн явуулах юм.

Энэ оны эхний 6 сарын хугацаанд манай компани 168 тэрбум төгрөгийн татвар, хураамжийг төлсөн бол 2009 оноос хойш нийт нэг их наяд гаруй төгрөгийг улсын төсөвт оруулжээ.

Оюу Толгойн бүтээн байгуулалт албан ёсоор эхэлснээс хойш 3 жил хүрэхгүй хугацаанд ил уурхай, баяжуулах үйлдвэрээ амжилттай босгож, одоо уурхайн үйл ажиллагаа бүрэн жигдэрч буй нь манай улсын Засгийн газар, олон улсын хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааны бат бөх түншлэлийг илтгэж байна.

Би эрдэс баялгийн салбарын мэргэжлийн геологич хүний хувьд Оюу Толгой шиг орд цаашид шинээр нээгдэх боломжтой гэж үздэг. Харин уул уурхайн хөрөнгө оруулалтын уур амьсгалыг сайжруулахад Оюу Толгойн өнөөгийн ололт амжилт, алдаа оноо томоохон сургамж, бас туршлага болно гэдэгт итгэдэг.

[Уурхайн ажиллах хүчнийг бэхжүүлэх нь]

Уул уурхай өндөр хөгжсөн улс орнуудын нэг онцлог бол тэдэнд ажиллах хүчний сонголт болон бусад дэд бүтцийн нөхцөлүүд сайн байдаг. Харин цөөхөн хүн амтай манай улсын хувьд уул уурхайн нарийн мэргэжлээр ажиллах ирээдүйн ажилчдыг бэлтгэх, мэргэжлийн сургалтын чиглэлээр тодорхой хөрөнгө оруулалт хийх шаардлага зайлшгүй гарч байна.

Компанийн зүгээс мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх сургалт, боловсролын хөтөлбөрт нэлээдгүй хөрөнгө оруулалтыг өнгөрсөн хугацаанд хийж ирлээ. Ер нь бид 5 жилийн хугацаанд нийт 126 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг олон нийтийг хамарсан болон өөрсдийн ажиллагсаддаа зориулсан сургалтын хөтөлбөрт зарцуулах юм.

Бидний хамтран ажилладаг Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвөөр дамжуулан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажил орон даяар өрнөж оюутнууд маань сургуулиа төгсөж, төрөл бүрийн салбарт ажлын байртай болж байгаа нь манай сургалтын хөтөлбөрийн үр дүнг бэлхэнээ харуулж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Оюу толгой компанийн зүгээс сургалт, боловсролд зарцуулсан хөрөнгө оруулалтын 63 хувь нь манай ажилчид бус, харин олон нийтэд чиглэсэн хөтөлбөрт зарцуулагдсан байна.

Оюу Толгойн ажилчдын хувьд эх орондоо мэргэжил дээшлүүлэхээс гадна гадаадын буюу Рио Тинто компанийн бусад уурхайд очиж туршлага судлах өргөн боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл манай монгол залуусын гарт зуу гаруй жилийн уул уурхайн туршлагтай амьдралын “Их сургуулиас ” суралцах боломж бүрэн байгаа юм.

Хамгийн сүүлд гэхэд л Австрали, АНУ, Өмнөд Африк дахь үйл ажиллагаа нь тогтворжсон Рио Тинтогийн бусад үйлдвэр, уурхайгаас эрдэм өвөрлөж ирсэн манай инженерүүд, өнөөдрийн Оюу Толгойн баяжмалыг үйлдвэрлэх ажлыг нугалахаас гадна сурсан, мэдсэн зүйлээ бусадтайгаа хуваалцаж, мэдлэг, туршлагаа Монголынхоо уул уурхайн салбарт нэвтрүүлж буй нь бахархалтай юм.

Үүнээс гадна Оюу Толгойд богино хугацаагаар томилогдон ирсэн нарийн мэргэжлийн үр чадвартай олон улсын шилдэг экспертүүд олон улсын туршлагыг Оюу Толгойд болон Монголын уул уурхайн салбарт нэвтрүүлж байна.

Өнөөдөр манай нийт ажиллах хүчний 90 хувь нь монголчуудаас бүрдээд байна. Хамгийн чухал нь маш олон монгол залуус эдгээр богино хугацааны томилолтоор ирсэн нарийн мэргэжлийн үр чадвартай гадаадын мэргэжилтнүүдийг орлож эхэлсэн бөгөөд олон монгол залуус Оюу Толгойд удирдах алба хашиж байна.

[Хангамжийн нэгдсэн сүлжээ бий болов]

Бид Монгол улсынхаа дотоодын зах зээлээс Оюу Толгойд шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг авч байж гэмээнэ улсынхаа эдийн засаг, бизнесийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулна гэж үздэг.

Манай бүтээн байгуулалт эхлэх үед бид ихэнхи бараа, үйлчилгээ, машин техникээ гаднаас оруулж ирэхээс өөр сонголт байгаагүй гэж хэлж болно. Харин уг явдал жил ирэх тусам сайжирч манай компанид бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлдэг үндэсний аж ахуйн нэгж, хувь хүмүүс нэмэгдсээр байна.

Гэхдээ тэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэхээсээ гадна хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайтар хангаж байгаа нь маш сайн үзүүлэлт юм.

Энэ жил л гэхэд бид бараа, үйлчилгээ, худалдан авахад зарцуулж буй нийт мөнгөн хөрөнгөний 50-иас дээш хувийг Монголынхоо үндэсний компаниудад зарцуулах зорилт тавин ажиллаж байгаа бол одоогоор худалдан авах гэрээ, хэлцлүүдийн 70 хувь аль хэдийнэ Монголын компаниудад очоод байна.

Олон улсын компаниудаас өндөр үнийн санал өгсөн ч Монгол компани манай худалдан авах тендерт шалгарч чадаж байгаагаас бид үндэснийхээ компаниудыг хэрхэн бодлогоор дэмжиж буйг харж болохоор байна.

Бид 1,500 гаруй үндэсний компаниудтай хамтран ажилладаг. Ингэхдээ тэднээс зөвхөн бараа, үйлчилгээг худалдан авахдаа бус тэдний аюулгүй ажиллагааны стандарт, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт өндөр шаардлага тавьж, Монгол улсад үрт хугацаанд тогтвортой ханган нийлүүлэх чадвар бүхий Хангамжийн сүлжээг бий болгоход хувь нэмрээ оруулж байна.

[Технологи]

Энэ танхимд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөөс манай уурхайд өөрийн биеэр очиж үзсэн хүн нэлээдгүй байгаа харагдаж байна. Манай үйлдвэр, уурхайд зочилсон хүмүүс голдуу хоёр үгээр Оюу Толгойг илэрхийлдэг. Тэр нь **“үнэхээр гайхалтай”**.

“Үнэхээр гайхалтай” гэсэн үгний цаана маш богино хугацаанд Монголын говьд дэлхийд өрсөлдөх чадвартай, олон улсын стандартуудыг хангасан, нарийн технологитой аж үйлдвэрийн цогцолборыг амжилттай барьжээ гэсэн санааг хэлж байна гэж ойлгодог.

Бид Оюу Толгойд уул уурхайн салбарын шилдэг техник, технологийг нэвтрүүлэн, өдөр тутмынхаа үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Ил уурхайг оновчлол, дизайн, тоног төхөөрөмжийн сонголт, шаардлагатай ажиллах хүчин, бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөлтийн дагуу явуулж байна. Ил уурхайн уулын ажлын ерөнхий төлөвлөлт нь АНУ-ын Бисарусын 34м.куб болон 56м.куб утгуурын багтаамж бүхий гидравлик болон цахилгаан экскаватор мөн Японы Коматцугийн 290т даацтай автосамосвалын болон Катерпилларын иж бүрдлүүдэд тулгуурлагдан хийгдэж байна.

Одоо Оюу толгойн баяжуулах үйлдвэр ил уурхайг түшиглэн хоногт 100000 тонн хүдэр боловсруулж байгаа болно.

Харин далд уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд дэлхийд маш цөөхөн уурхайд ашигладаг блокчлон олборлох аргыг нэвтрүүлэх их хэмжээний бэлтгэл ажлуудыг хийснийг харж болно.

Оюу Толгойг бид хамгийн бага ус ашигладаг уурхай болгон хөгжүүлэх зорилт тавьсан.

Манайтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг дэлхийн бусад уурхайд нэг тонн хүдэр боловсруулахын тулд 1.27 шоо метр ус ашигладаг гэсэн судалгаа бий. Харин хамгийн орчин үеийн усны хэмнэлт бүхий технологи нэвтрүүлж чадсан Оюу Толгойн уурхай энэ оны эхний хагас жилийн дундаж дүнгээр боловсруулж буй нэг тонн хүдэр тутамдаа 0.43 шоо метр ус ашиглажээ.

[Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа]

Оюу Толгой компанид гурваас дээш хүн ажил төрлийн уулзалт, хурал хийсэн тохиолдолд заавал аюулгүй ажиллагааны зөвлөгөө, зөвлөмжөөр уг уулзалт, хурал эхэлдэг.

Рио Тинтогийн бүх уурхайд ашиглагддаг энэ соёл Монгол улсад, тэр тусмаа манай компанид маш сайн хэвшиж байгаа. Ингэснээр аюулгүй ажиллагаа бол зөвхөн уурхайн ажилчдад бус, мөн манай албан оффисийн ажилчид, манайд зочилж буй зочдын хувьд ч хамаатай гэдгийг байнга сануулж байдаг.

Болгоомжгүй хандвал уул уурхай бол осол гаргах магадлалтай эрсдэлтэй салбар. Тиймээс бид ажиллах хүчнийхээ аюулгүй байдал, эрүүл мэндийг нэн чухалчилж үздэг юм.

Оюу Толгой хэдийгээр маш залуу, дөнгөж үйлдвэрлэлээ эхэлж буй уурхай хэдий ч Рио Тинтогийн удирддаг олон уурхайнуудаас хамгийн аюулгүй, осол аваар багатай уурхайн нэг юм.

Рио Тинто компанийн удирддаг, дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй уул уурхай дахь осол гэмтлийн дундаж давтамжаас Оюу Толгойнх

харьцангуй бага байгаа нь манай уурхайн хувьд, бас Монгол улсын уул уурхайн салбарын хувьд маш том, эерэг үзүүлэлт юм.

[Хариуцлагатай уурхай]

Та бүхний анхаарлыг хариуцлагатай уул уурхайн тухайд хандуулъя.

Анх удаагаа ийм том төслийг эхлүүлсэн амжилтын цаана мэдээж алдаа, оноо байхыг үгүйсгэхгүй. Мөн ийм гэнэтийн бүтээн байгуулалт, үйлдвэржилтээс үүдэн гарч болзошгүй байгаль орчны болон нийгмийн өөрчлөлтөд хүмүүс бэлэн биш байж болох юм.

Мэдээж Засгийн газрын зүгээс эдийн засгийн хөгжлийг түргэтгэх ажлын хажуугаар байгаль орчны асуудалд онцгой анхаарлаа хандуулж байгаа.

Оюу Толгой компани говьд тоосжилт үүсгэж, говийн усны эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тухай болгоомжлол хүмүүст байдаг. Харин Засгийн газрын зүгээс энэ асуудлыг бүрэн анхаарч, бидний үйл ажиллагаанд сайн хяналт хийж байгаа гэж ойлгодог. Үүний зэрэгцээ компанийн зүгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, үүргээ хариуцлагатай биелүүлж байгаа юм.

Жишээ нь, Оюу Толгой компанийн усны хэрэглээг маш олон талын хөндлөнгийн болон дотоод хяналт дор явуулдаг. Усны хэрэглээ болон чанар, нөөц нь өдөрт, долоо хоногт, сард, жилд хэрхэн өөрчлөгдөж буйд манай байгаль орчны мэргэжилтнүүд болон **Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны** зүгээс байнга хяналт тавьдаг. Нутгийн иргэд ч өөрсдийн ундны усны чанар, худгийн түвшинд ямар өөрчлөлт орж буйг давхар шалгаад явж байдаг.

Мөн манай компанийн бүхий л үйл ажиллагаанд олон улсын санхүүжүүлэгч байгууллагууд байнгын мэргэжлийн хяналт хийдэг. Жилд гурван удаа Оюу Толгойн байгаль орчин, ажиллах хүчний үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаас аудитын шалгалт ордог. Ингэхдээ компанийн зүгээс гаргасан 742 амлалт үүргийг хэрхэн биелж буйд аудит хийж алдаа, дутагдал гарсан тохиолдолд түүнийг цаашид тогтмол сайжруулан ажиллах боломжийг олгодог.

Манай улсын уул уурхайн салбарт олон улсын энэ төрлийн аудитыг анх удаа Оюу Толгойгоос эхэлж буйд бид бахардаг.

[Дүгнэлт]

Өнөөдрийн Та бидний оролцож буй энэхүү арга хэмжээ нь хүчирхэг эдийн засгийг хөгжүүлэхэд Засгийн газар болон шийдвэр гаргагч талуудад ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Ойрын ирээдүйд Монголын төдийгүй дэлхийн эдийн засагт **Эрдэс баялгийн салбар** томоохон байр суурийг эзлэх нь тодорхой байгаа энэ цаг үед хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх буюу бусад аж үйлдвэрийн салбарт анхаарлаа давхар хандуулах нь алсыг харсан шийдэл гэж үзэж байна.

Энэ ч утгаараа Монголын хамгийн том уул уурхайн төсөл болох Оюу Толгойн зөвхөн уул уурхай салбарыг хөгжүүлээд зогсохгүй бусад салбаруудад үр өгөөжөө шууд болон шууд бусаар өгнө гэдэгт бид итгэдэг.

Орон нутагт мэргэжлийн сургуулиуд барьж байгуулах, дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх, Өмнийн говьд онгоцны буудал, зам харгуй барих гэх зэрэг манай төсөл, хөтөлбөрүүд энэхүү үр өгөөжийн эхлэл гэж би үздэг.

Би улсынхаа ирээдүйг үнэхээр гэрэл, гэгээтэй, сайн сайхнаар төсөөлдөг. Нэг л өдөр бидний ярианы сэдэв Оюу Толгой бус, харин Оюу Толгой шиг олон томоохон төсөл хэрэгжсэн, мөн Оюу Толгой нь томоохон эдийн засгийн багахан хэсэг нь болсон тийм л улс орон болж хөгжинө гэж төсөөлдөг.

Харин ийм болж хөгжих замыг Оюу Толгой чиглүүлж, басхүү ийм болж хөгжих хандлага, жишгийг Оюу Толгой тодорхойлж байгаа гэдэгтээ Та бүхэн санал нийлэх биз ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

[Төгсгөл]